

Монголбанк-нд тайлагнах нь

2022 он 4 сарын 15

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Уламбаярын 2022 оны 1-р улирлын тайлан

Миний бие Баянсангийн Уламбаяр нь өнгөрсөн 2022 оны 1-р улиралд ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр гэрээний дагуу үргэлжлүүлэн ажиллалаа. 2021 оны 12 сарын 25-нд тайлагнаснаас хойш хугацаанд доорх хурлуудад оролцож ажилласан байна.

Уг тайланг, “Банкны тухай хууль” (“Банкны Хууль” гэх), “Компанийн тухай хууль” (“Компанийн Хууль” гэх), Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Журам” гэх), ХасБанкны дүрэм (“Дүрэм” гэх) гэх мэт холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэсэн ажлаа тусгаж нэгтгэсэн болно.

1. Оролцож ажилласан хурлууд

2022/01/27 ТУЗ-ийн ээлжит бус хурал (онлайн)

- Банкны дараагийн 5 жилийн стратеги болон санхүүгийн таамаглалын талаар хэлэлцсэн. Тус таамаглалын дэлгэрэнгүй тоон мэдээлэл нь IPO-той холбоотойгоор хөндлөнгийн үнэлгээний компанийн ажилд зориулж бэлдэгдсэн.

2022/02/25 ТУЗ-ийн Аудитын Хорооны ээлжит бус хурал (онлайн)

- ТУЗ-ийн ээлжит бус хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлыг хэлэлцэж, ТУЗ-д танилцуулж батлуулахаар Аудитын хорооны гишүүд санал нэгтэй шийдсэн:
Ernst&Young компанийн багаас танилцуулагдсан “2021 оны эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан”
 - Миний зүгээс зөрүүтэй байр суурь байгаагүй.
 - Хурлын өмнө, зарим мэдээллийн талаар Санхүү хариуцсан захирал болон Дотоод аудитортой ярилцаж тодруулга авсан.
 - Шинээр томилогдсон Аудитын Хорооны даргын хувиар, миний бие хорооны хурлыг удирдаж явуулсан болно.

2022/02/25 ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны ээлжит бус хурал (онлайн)

- Ажиглагчаар оролцсон.
- “ТУЗ-ийн хараат бус гишүүдийг шалгаруулах, батлах процесс”, “2021 оны үр дүнгийн шагнал урамшууллын багцын тухай”, “2021 оны гүйцэтгэх захирлын үнэлгээ болон үр дүнгийн шагнал урамшуулал”, “2021 оны ТУЗ-ийн даргын үнэлгээ болон үр дүнгийн шагнал урамшуулал”, “2021 оны PSP” гэсэн сэдвүүдээр танилцуулга, хэлэлцүүлэг өрнөсөн.

2022/02/25 ТУЗ-ийн ээлжит бус хурал (онлайн)

- ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
 - 1) ”2021 оны үр дүнгийн шагнал урамшууллын багцын дүнг батлах”,
 - 2) “2021 оны гүйцэтгэх захирлын үр дүнгийн шагнал урамшууллыг батлах”,
 - 3) “2021 оны ТУЗ-ийн даргын үр дүнгийн шагнал урамшууллыг батлах”.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- ТУЗ-ийн Аудитын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
 - 1) Ernst&Young компанийн багаас танилцуулагдсан ”2021 оны эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан”
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- Менежментийн зүгээс бэлдсэн дараах асуудлуудтай танилцсан: “2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн тайлан”, “2021 оны ногдол ашиг тараах шийдвэр”, “ХасБанкны компанийн шинэ дүрмийн 8.6 заалтын тодруулга”, “2022 оны хувь нийлүүлэгчдийн хурлын зарын тов”.
 - 1) 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн тайлан”-ийг ТУЗ санал нэгтэй баталсан.
 - 2) “2021 оны ногдол ашиг тараах шийдвэр”-ийг ТУЗ санал нэгтэй баталсан.
 - 3) “2022 оны хувь нийлүүлэгчдийн хурлын зарын тов” 4/26-ний өдрийг, ТУЗ санал нэгтэй баталсан
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

2022/01 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны шийдвэр (онлайн)

- Доорх хүсэлтийг хороогоор хэлэлцэж дэмжсэн шийдвэр гаргасан.
 - М** компаниас ирсэн зээлийн хүсэлт. Тус компани нь Банкны хувьцаа нийлүүлэгчийн хөрөнгө оруулалттай тул, хороогоор шийдсэн.
(Журмын 5.2.3 үүргийн дагуу. Хорооны шийдвэртэй ижил, дэмжсэн санал өгсөн)

2022/02 ТУЗ-ийн Аудитын Хорооны шийдвэр (онлайн)

- Аудитын Хорооны дарга Maurice Lam нь ТУЗ-ийн гишүүний ажлаасаа чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн тул, шинэ Аудитын хорооны даргын санал хураалт болсон. ТУЗ-ийн даргаас миний нэрийг санал болгож, хороогоор дэмжсэн шийдвэр гарсан.
 - Миний зүгээс түдгэлзсэн санал өгсөн. Банкны хараат бус хоёр гишүүний нэгний хувьд, хорооны энэ шийдвэрийг хүндэтгэн хүлээж авч, ажиллахаар шийдсэн.

2022/03/29 ТУЗ-ийн Аудитын Хорооны ээлжит хурал (онлайн)

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн. Асуудлын талаар дэлгэрэнгүй материалыг урьдчилж авч танилцсан байсан тул, гишүүдээс зөвхөн нэмэлт асуулт тодруулгыг л хүлээж авч, товч хэлэлцүүлэг хийсэн:
“Картын бизнес, цахим сувгийн үйл ажиллагааны дотоод аудит шалгалтын тайлан”, “Хэрэглэгчийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны дотоод аудит шалгалтын тайлан”, “Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх ажиллагааны дотоод аудит шалгалтын тайлан”, ”IT дата шилжүүлэх зөвлөх үйл ажиллагааны дотоод

аудит шалгалтын тайлан”, ”Дотоод аудитын газрын 2022 оны төсвийн тодотгол”, “Хамаарал бүхий этгээдүүдийн улирлын тайлан”.

- “Дотоод аудитын газрын 2022 оны төсвийн тодотгол”-ийг Аудитын хорооны гишүүд санал нэгтэй баталсан.
 - Миний зүгээс зөрүүтэй байр суурь байгаагүй.
 - Аудитын Хорооны даргын хувиар, миний бие хурлыг удирдаж явуулсан.
 - Хурлын өмнө, зарим мэдээллийн талаар Дотоод аудитортой ярилцаж тодруулга авсан.

2022/03/29 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны ээлжит хурал (онлайн)

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн:
 - “2022 оны 2 сарын байдлаарх Эрсдэлийн тайлан”, “Оросын Холбооны Улсын эсрэг тавигдсан олон улсын хорионоос үүдэх үр нөлөө”, “Сэргээх(Recovery) төлөвлөгөө, 2022”, ”2022 оны 1-р улирлын хянан нийцүүлэлтийн тайлан”.
- ”2022 оны 2 сарын байдлаарх Эрсдэлийн тайлан” дээр, миний зүгээс, ойрын хэдэн 7 хоногийн доллар төгрөгийн ханшын огцом өөрчлөлт тус тайланд туссан эсэх талаар, мөн цаашид үргэлжлэн үед гарах үр нөлөө, эрсдэлийн талаар болгоомжлуулж, тодруулсан.
- “Орос Холбооны Улсын эсрэг тавигдсан олон улсын хорионоос үүдэх үр нөлөө” дээр, миний зүгээс, ОХУ-аас импортоддог эрчим хүч, тогны тасалдлын эрсдэл тайланд тусаагүйг тэмдэглэж, гэнэтийн тасалдал үүссэн тохиолдолд чухал томоохон уул уурхай, үйлдвэрүүдийн ажиллагааны доголдоос гарах үр дагаврыг болгоомжлуулж, тодруулсан.

Мөн, Оюу Толгой төсөлд хэрэглэгддэг түлш болон бусад олон бүтээгдэхүүнүүд ОХУ-аас болон бусад улсаас дамжин ирж нийлүүлэгддэг тул, ханган нийлүүлэлтийн бүс нутгийн ноцтой доголдол гарсан тохиолдолд тус уурхайн зогсолттой холбоотой эдийн засгийн хүчтэй сөрөг нөлөөний талаар болгоомжлуулж, хэлэлцүүлсэн.
- “Сэргээх(Recovery) төлөвлөгөө, 2022”-ийг хорооны гишүүд санал нэгтэй баталсан.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

2022/03/29 ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны ээлжит хурал (онлайн)

- Ажиглагчаар оролцсон.
- “Ажилчдын урт хугацааны урамшууллын схем”, “ТУЗ-ийн хараат бус гишүүнийг шалгаруулах процессийн явц”, “ТУЗ-ийн гишүүн Maurice Lam-ийн чөлөөлөгдөх өргөдлийг хүлээж авах шийдвэр”, “ТУЗ-ийн гишүүдийн дахин сонгууль, сунгах талаар”, “ТУЗ-ийн өөрийн болон гишүүдийн үнэлгээ (МонголБанк болон хуулийн шаардлагууд)”, “ТУЗ-ийн ахлах зөвлөхийн гэрээний сунгалтын талаар” гэсэн сэдвүүдээр танилцуулга, хэлэлцүүлэг өрнөсөн.

2022/03/30 ТУЗ-ийн ээлжит хурал (онлайн)

- ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
 - 1) “ТУЗ-ийн гишүүн Maurice Lam-ийн чөлөөлөгдөх өргөдлийг хүлээж авах”
 - 2) “ТУЗ-ийн ахлах зөвлөхийн гэрээний сунгалт”.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

- ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
 - 1) ”Сэргээх(Recovery) төлөвлөгөө, 2022”
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- ТУЗ-ийн Аудитын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
 - 1) ”Дотоод аудитын газрын 2022 оны төсвийн тодотгол”
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- Менежментийн зүгээс бэлдсэн дараах асуудлуудтай танилцсан: “Банкны үйл ажиллагааны 2022 оны 2-р сарын байдлаарх явцын тайлан”, “IPO төслийн явц”, “ХасБанкны ХК болох үеийн компанийн шинэ дүрэм”, “Funding Plan”, “IT шинэчлэл, дижитал банкны явц”, “D&O даатгал”, “ТУЗ-ийн шинэ нарийн бичгийн ажилтын томилгоо”, “ТУЗ-ийн гишүүдийн дахин сонгууль, сунгалт”, “ХасБанкны дүрэмд ТУЗ-ийн гишүүдийн тоог 12 болгох өөрчлөлт”, “Оросын Холбооны Улсын эсрэг тавигдсан олон улсын хорионоос үүдэх үр нөлөө”, “Холбоотой этгээдүүдтэй хийсэн хэлцлийг батлах”.
 - 1) “IPO Prospectus-ийн талаар 4/12-нд дахин хурлаар хэлэлцэх” -ийг ТУЗ санал нэгтэй баталсан.
 - 2) “Funding Plan”-ийг ТУЗ санал нэгтэй баталсан.
 - 3) “ХасБанкны дүрэмд ТУЗ-ийн гишүүдийн тоог 12 болгох өөрчлөлт”-ийг ТУЗ санал нэгтэй баталсан.
 - 4) “ТУЗ-ийн журамд саналын тоо тэнцсэн тохиолдол дахь ТУЗ-ийн даргын саналыг давуу болгох өөрчлөлт”-ийг ТУЗ санал нэгтэй баталсан.
 - 5) “Холбоотой этгээдүүдтэй хийсэн хэлцлийг батлах”-ийг ТУЗ санал нэгтэй баталсан.

(Журмын 5.2.3 үүргийн дагуу. Дэмжсэн санал өгсөн)

2. Банкны засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа

Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна. Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.

ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны ба түүний харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, аливаа холбогдох хууль журмыг зөрчсөн ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.

3. Бусад

- Банкны төлөвлөсөн IPO-ийн бэлтгэл ажлын хүрээнд, хуулийн фирмийн гүйцэтгэж буй ажилтай холбоотойгоор, ТУЗ-ийн гишүүний хувьд баталгаа болон холбогдох материалуудыг 2 сард гаргаж өгсөн.
- Аудитын Хорооны даргаар миний бие шинээр томилогдсон тул, Банкны хөндлөнгийн санхүүгийн аудитын компани болох Ernst&Young-ийн хариуцсан багийнхантай ажлын ерөнхий онлайн уулзалтыг 2/24-нд хийсэн.
- Дотоод аудитортой, ажлын явцын талаар 2 сард биечлэн уулзалт хийсэн.
- ХасБанкны нийт ажилчдын оны тайлангийн хуралд, 1/23-нд ТУЗ-ийн гишүүний хувиар биечлэн оролцсон.

4. Компанийн тухай хуулийн 79.3. Хараат бус гишүүний нэмэлт үүргийн хүрээнд

79.3.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

- Уг заалтын дагуу, хяналтыг тавьж зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар анхаарал тавин, бүх хурлуудад оролцож шийдвэрүүдээ гаргасан. Тайлангийн хугацаанд, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого шийдвэрүүд нь уг заалтанд тодорхойлогдохуйц сөргөөр нөлөөлсөн зүйл ажиглагдаагүй болно.
- Энэ талаар, тайлан дахь оролцсон хурал тус бүрийн тайлбарт шаардлагатай бол тэмдэглэж, тайлангийн дээрх 3-р бүлэгт бас тодорхой сийрүүлсэн.

79.3.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

- Уг заалтын хүрээнд, гүйцэтгэх удирдлага нь ил тод, нээлттэй байдлыг үргэлжлүүлэн хэвийн хангаж ажиллаж байгаа бөгөөд, тусгайчлан үүрэг өгч ажиллахаар нөхцөл байдал үүсээгүй болно.

79.3.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

- Тус тайлангийн хугацаанд, хувь нийлүүлэгчдийн хурал болоогүй болно.

Хүндэтгэсэн,



Б. Уламбаяр

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн